

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 дүгээр
сарын 14-ны өдөр

Дугаар А-45

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, “Үндэсний аян өрнүүлэх тухай” Засгийн газрын 2016 оны 212 дугаар тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мах, сүүний анхдугаар аяныг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр, Атрын III аяныг сэргээн хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Төлөвлөгөө тус бүрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг яамны холбогдох газар, хэлтэс, агентлаг, улсын төсвийн байгууллагад, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Баяртулга/-д тус тус үүрэг болгосугай.

3. Атрын III аяныг үргэлжлүүлэх болон Мах, сүүний анхдугаар аяныг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахыг холбогдох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод зөвлөсүгэй.

САЙД

П.СЭРГЭЛЭН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017
оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн А-45 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага			Хэрэгжих хугацаа
				Үндсэн	Хамтрагч	Оролцогч	
1. Мах, сүүний анхдугаар аян зохион байгуулах эрх зүй, эдийн засгийн орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд							
1	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг батлуулах, хэрэгжилтийг хангах	Хууль	Хуулийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ /БТГ, ХХ/	МЭҮГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ХХААГ, ТББ	2017-2020
2	Малын генетик нөөцийн тухай хуулийг батлуулах, хэрэгжилтийг хангах	Хууль	Хуулийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ /БТГ, ХХ/	МЭҮГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ХХААГ, ТББ	2017-2020
3	Мах, сүү боловсруулах жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх, хөдөө аж ахуйн болон боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гадаад орнуудаас хөнгөлөлттэй зээл, лизингээр авах чиглэлд санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах	Засгийн газрын тогтоол, тоног төхөөрөмж	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ЖДҮХБХЗГ /	СЯ, ГЕГ, Хөгжлийн банк	ЖДҮХС, ТББ, ААН	2017-2020
4	Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийг батлуулах, хэрэгжилтийг хангах	Үндэсний хөтөлбөр	Хөтөлбөрийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ /БТГ/	МЭҮГ	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2020
5	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг батлуулах, хэрэгжилтийг хангах	Үндэсний хөтөлбөр	Хөтөлбөрийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ /БТГ, МААБХЗГ/	МЭҮГ	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2020

6	Хөдөө аж ахуйн, үйлдвэрлэлийн, эрүүл ахуйн зохистой дадлыг тус тус нэвтрүүлэх зааврыг батлуулах, хэрэгжилтийг хангах	Заавар	Зааврын хэрэгжилтээр	ХХААХҮЯ /БТГ, ХҮБХЗГ/	МХЕГ	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ, ААН	2017-2020
7	Гадаад худалдааны уламжлалт түнш орнуудтай байгуулсан мал эмнэлэг, хорио цээрийн хэлэлцээрийг хянан үзэж шинэчлэн байгуулах, экспортыг дэмжиж, боломжтой улс орнуудтай шинээр гэрээ байгуулах	Хэлэлцээр	Хэлэлцээрийг хянан үзэж, шинэчлэн байгуулсан байна.	ХХААХҮЯ /БТГ, ГХАХ/	МЭҮГ, МХЕГ	ТББ, ААН	2017-2020
8	Малын ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох суурь судалгааны ажил хийх, шаардлагатай арга хэмжээний санал боловсруулах	Суурь судалгаа	Судалгаанд үндэслэн санал боловсруулсан байна.	ХХААХҮЯ /БТГ, ХҮБХЗГ/	ҮСХ, МЭҮГ, ХААИС	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2020
9	Мах, сүүний үйлдвэрийн технологийн шат дамжлага дахь хорогдлын норм тогтоох судалгааны ажил хийх, шаардлагатай арга хэмжээний санал боловсруулах	Хорогдлын норм	Нормыг батлуулж, шаардлагатай санал боловсруулж шийдвэрлүүлсэн байна.	ХХААХҮЯ /БТГ, ХҮБХЗГ/	ТББ	ШУТИС, ХААИС, ААН	2018-2020
10	Монгол малын махны физик, химийн үзүүлэлт, онцлог, давуу талыг тодорхойлох судалгаа хийх	Судалгаа	Судалгаанд үндэслэн санал боловсруулж шийдвэрлүүлсэн байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	ҮСХ, МЭҮГ, ХААИС, ШУТИС	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2020
11	Мах, сүүний нөөцийг аймаг, сумын хэмжээнд тооцох, боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, байршил, нөөцтэй уялдуулан үйлдвэржилтийн зураглалыг гаргах	Зураглал	Зураглалыг бодлого, хэрэгжилтэд ашигласан байна.	ХХААХҮЯ /БТГ, ХҮБХЗГ/	ТББ	Аймаг, нийслэлийн ХХААГ	2017-2020
2. Тэжээлийн тариалан, мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, түүхий эдийн улирлын хамаарлыг бууруулах зорилтын хүрээнд							
12	Улаан буудай тариалдаг аж ахуйн нэгжийн сэлгээний талбайд малын тэжээл болон олон наст тэжээл тариалалтыг нэмэгдүүлэх	Тэжээлийн тариалан, үйлдвэрлэл	Улаан буудай тариалагч аж ахуйн нэгжийн 60 хувиас доошгүй сэлгээний талбайд нь тэжээлийн ургамал тариалж хэвшүүлнэ.	ХХААХҮЯ /ГТБХЗГ/ МААБХЗГ	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020

13	Газар тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх тэжээлийн үйлдвэр байгуулах ажлыг зохион байгуулах	Тэжээлийн үйлдвэр	Тариаланч, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид эрчимжсэн мал аж ахуйг эрхлүүлсэн байна.	ХХААХҮЯ /, ГТБХЗГ/ МААБХЗГ	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
14	Хүн ам олноор төвлөрсөн хот суурин газрын сүүний хэрэгцээг хангах зорилгоор сүүний чиглэлийн үхрийн аж ахуйн фермерүүдийг нэмэгдүүлэн гарал үүсэл нь баталгаажсан эрүүл ахуйн шаардлага хангасан малын сүүг үйлдвэрлэгчид нийлүүлэх	Эдийн засгийн механизм	Боловсруулах үйлдвэрлэлд ашиглах сүүний 60 хувийг эрчимжсэн аж ахуйгаас бэлтгэсэн байна.	ХХААХҮЯ /БТГ, ХҮБХЗГ/ МААБХЗГ	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
15	Газар тариалангийн бүс нутгийг дагуулан махны чиглэлийн үхэр, хонь, гахайн фермийн аж ахуйг шинээр бий болгох	Санхүүгийн дэмжлэг	Боловсруулах үйлдвэрлэлд нийлүүлэх махны 35 хувийг эрчимжсэн аж ахуйгаас бэлтгэсэн байна.	ХХААХҮЯ /МААБХЗГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
16	Мах сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд өндөр ашиг шимтэй мал амьтан, гүн хөлдөөсөн үр, хөврөл үрийг импортлон үнээг нь хээлтүүлэн энэ төрлийн аж ахуй эрхлэдэг мах сүүний чиглэлийн үхрийн 80-аас доошгүй хувийг цэвэр үүлдрийн болон 1-р үеийн эрлийз үхэр болгон нэгжээс авах ашиг шимийг 40 хувь болгон нэмэгдүүлэх	Санхүүгийн дэмжлэг	Төрөл бүрийн дэмжлэгийг 100 хувиас доошгүй аж ахуйн нэгжид үзүүлсэн байна.	ХХААХҮЯ /МААБХЗГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
17	Бэлчээрийн маллагаатай үхэр, хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, өсвөр малыг богино хугацаанд бордох технологийг боловсруулж нэвтрүүлэхэд бодлогын дэмжлэг, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах	Санхүүгийн дэмжлэг	Бэлчээрийн маллагаатай үхэр, хонийг махны чиглэлээр өсгөн бойжуулах, өсвөр малыг богино хугацаанд бордох технологийг боловсруулан мөрдүүлсэн байна.	ХХААХҮЯ /МААБХЗГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020

18	Өндөр ашиг шимтэй махны болон сүүний чиглэлийн импортоор орж ирсэн цэвэр үүлдрийн үхрүүдийн үр төл, хээлтүүлэгчийг авч энэ төрлийн аж ахуй эрхлэгч, жижиг дунд фермерүүдэд, эргэн төлөгдөх нөхцлөөр олгон жижиг дунд аж ахуй эрхлэгчдийн нийт үхрийн 80-аас доошгүй хувийг цэвэр болон 1-р үеийн эрлийз үхэр болгож нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх	Дэмжлэг	120 аж ахуйн нэгжид олгосон байна.	ХХААХҮЯ /МААБХЗГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
19	Мах сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч аж ахуйн нэгж иргэнд хадлан, ногоон тэжээл тариалах талбайг хууль журамд нийцүүлэн ашиглуулах асуудлыг шийдвэрлэх	Хадлангийн талбайн ашиглалт	Хадлангийн талбайг ашиглуулсан байна.	ХХААХҮЯ /БТГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
20	Сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч фермүүд, жижиг дунд аж ахуйнуудыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангах сүү нийлүүлэх цахилгаан саалтуураар саах нөхцөл бүрдүүлэх	Цахилгаан саалтуурын дэмжлэг	60-аас доошгүй хувийг хангасан байна.	ХХААХҮЯ /МААБХЗГ/	ОУ-ын хөтөлбөр, төслийн байгууллага	ТББ, ААН	2017-2020
21	Мах, сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгчдэд менежментийн болон зохистой дадлын сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Сургалт, сурталчилгаа	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
3. Мах, сүү бэлтгэн нийлүүлэлтийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд							
22	Мал тээвэрлэх, тууварлах, талаар шаардлагатай арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэх	Судалгаа	Судалгаанд үндэслэн шаардлагатай арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлсэн байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ, МААБХЗГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2018-2019
23	Үйлдвэрт мах, сүү бэлтгэн нийлүүлэх хоршоодод сургалт, сурталчилгаа зохион байгуулах.	Дэмжлэг, сургалт, сурталчилгаа	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ЖДҮХБХЗГ /	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2018-2019

24	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржээр мал, мах, хуурай сүү арилжих нөхцөл, боломжийг бүрдүүлэх	Биржийн арилжаа	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /БТГ/	Хөдөө аж ахуйн бирж	ААН	2018-2020
25	Сүүний хөргөлтийн техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, орон нутагт цөцгийн тос ялгах сеператор, сүүний зориулалтын бидон саваар хангах	Тоног төхөөрөмж	Сүүний хөргөлтийн 50 тоног төхөөрөмж, 150 ширхэг сеператор, 300 ширхэг бидон савыг олгосон байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	ОУ-ын хөтөлбөр, төслийн байгууллага	ТББ, ААН	2017-2020
26	Орон нутагт мал нядлагааны явуулын жижиг загвар үйлдвэр байгуулахыг дэмжих	Явуулын загвар жижиг үйлдвэр	Орон нутагт явуулын нийт 25 загвар үйлдвэр байгуулагдсан байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ, ХөнҮБХЗГ/	Аймгийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
27	Мах, сүү бэлтгэн нийлүүлэх чиглэлээр малчид, фермерүүдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах	Сургалт, сурталчилгаа	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
4. Мах, сүүний боловсруулах салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд							
28	Мал сүргийн эргэлтийг харгалзан орон нутагт мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийг хамтран байгуулах	Үйлдвэр	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	СЯ, олон улсын хөтөлбөр, төслийн байгууллага	ТББ, ААН	2018-2020
29	Экспортын зөвшөөрөлтэй, дулааны аргаар мах боловсруулах үйлдвэрүүдийн өргөтгөл, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх.	Тоног төхөөрөмжийн шинэчлэл	Дулааны аргаар боловсруулсан махны хэмжээг 30 мян тн хүргэж нэмэгдүүлсэн байна.	ХХААХҮЯ /БТГ, ХҮБХЗГ/	ҮХГ, Нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2017-2020
30	Мал цуглуулах, бордох, төхөөрөх, боловсруулах болон эрдэм шинжилгээ, судалгааны хоршсон зохион байгуулалт бүхий хувийн хэвшлийн төслийг дэмжих, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, сурталчлах	Үйлдвэрлэл, технологийн парк	Төслийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Хэрэгжүүлэгч ААН	ТББ	2017-2020

31	Орон нутагт борц үйлдвэрлэх хувийн хэвшлийн санаачилгыг өрнүүлэх	Үйлдвэр	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Аймгийн ХХААГ	ААН	2017-2020
32	Хүүхдийн сүү, сүүн тэжээлийн үйлдвэр бий болгох асуудлыг зохион байгуулах	Үйлдвэр	Хүүхдийн сүү, сүүн тэжээлийн 1 үйлдвэр байгуулагдсан байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Олон улсын хөтөлбөр, төслийн байгууллага	ААН	2017-2020
33	Орон нутгийн нөөцийг ашиглах, сүүг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор “Монгол хуурай сүү” төслийг хамтран хэрэгжүүлэх	Төсөл	Төслийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Хэрэгжүүлэгч ААН	Хөгжлийн банк, Төрийн банк, аймгийн ХХААГ, ТББ	2017-2020
34	Орон нутагт “Ээдэмцэр” төслийг хамтран хэрэгжүүлэх	Төсөл	Төслийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Хэрэгжүүлэгч ААН	ҮХГ, аймгийн ХХААГ, ТББ	2017-2020
35	Орон нутагт “Монгол ямааны хуурай сүү” төслийг хамтран хэрэгжүүлэх	Төсөл	Төслийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ	Хэрэгжүүлэгч ААН	Хөгжлийн банк, аймгийн ХХААГ, ТББ	2017-2020
36	Сумдад бяслаг бэлтгэж, бойжуулах үйлдвэрийг төв, суурин газрыг түшиглэн байгуулах замаар бяслагны үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх	Төсөл	Төслийн хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ЖДҮХБХЗГ /	Хэрэгжүүлэгч ААН	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	2017-2020
37	Мал, амьтны /гахай, тахиа, загас/-ы гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, шинэ технологи нэвтрүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зорилгоор шинэ шугам суурилуулах, үйлдвэрлэлийг өргөтгөх	Бүтээгдэхүүний нэр, төрөл	Бүтээгдэхүүний нэр, төрөл жил бүр 1-2-оор нэмэгдсэн байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ	ААН	2017-2020
38	Ингэ, гүү, сарлаг, ямаа, хонины сүүний нөөцийг ашиглах, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр судалгаа хийх, нэвтрүүлэх, боловсруулах	Судалгаа, дэмжлэг	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Аймгийн ХХААГ, ХААИС, ШУТИС	ТББ, ААН	2018-2020

39	Мах, сүүний боловсруулах үйлдвэрийн дотоод хяналтын лабораторийг бэхжүүлэх	Дотоод хяналтын лаборатори	Дотоод хяналтын 30 лабораторийг бэхжүүлсэн байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	Аймаг, нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2018-2020
40	Мах, сүүний боловсруулах салбарын хүний нөөцийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах	Сургалт	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	ТББ	ААН	2017-2020
41	Сүүний цэвэр өсгөврийн хөрөнгийн үйлдвэр бий болгох асуудлыг зохион байгуулах	Үйлдвэр	Үйлдвэр байгуулагдсан байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ, ХНХҮЗХ/	ААН	ТББ	2018-2020
5. Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний дотоодын хэрэглээ, экспортыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд							
42	УБ хотын баруун, зүүн талд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан, зориулалтын хөргөлттэй агуулах бүхий мах, махан бүтээгдэхүүний орчин үеийн бөөний худалдааны нэгдсэн төв байгуулахыг бодлогоор дэмжиж мал төхөөрөх үйлдвэр болон ХАА-н биржийн үйл ажиллагаатай холбох шийдэл гарган ажиллах	Худалдааны нэгдсэн төв	Улаанбаатар хотын зүүн болон баруун талд бөөний худалдааны нэгдсэн төв байгуулагдсан байна.	ХХААХҮЯ /БТГ, ХҮБХЗГ/	Нийслэлийн ХХААГ	ТББ, ААН	2019-2020
43	Дотоодын үйлдвэрийн мах, сүүн бүтээгдэхүүнийг түлхүү худалдан авах хэрэглэгчийн соёлыг төлөвшүүлэх, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сурталчилгаа зохион байгуулах	Сургалт, сурталчилгаа	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	ШӨХТГ	Аймаг, нийслэлийн ХХААГ, ТББ, ААН	2017-2020
44	"Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн бага ангийн сурагчдад "өдөрт нэг аяга сүү" арга хэмжээг хэрэгжүүлэх, сүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх	Хөтөлбөрийн өргөжилт	Улаанбаатар хотын ЕБС-ийн нийт 110-117 мянган хүүхэд хамрагдсан байна.	ХХААХҮЯ /ХҮБХЗГ, ХөнҮБХЗГ/	БСШУСЯ	Нийслэлийн ХХААГ, ЕБС, ААН	2018-2020

45	Цэцэрлэг, сургууль, цэргийн анги, хорих анги, дулааны цахилгаан станц зэрэг төрийн байгууллагын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулсан махыг төрийн худалдан авалтаар нийлүүлэх нөхцөл, боломжийг судлах, шаардлагатай арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэх	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны борлуулалт	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /БТГ, ХҮБХЗГ/	ТӨБЗГ	Аймаг, нийслэлийн ХХААГ	2017-2020
46	Худалдааны төвд үндэсний үйлдвэрийн махан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүний тусгай тасаг байгуулахыг зохион байгуулалтын хувьд дэмжих	Бүтээгдэхүүний тасаг	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХНХҮЗХ/	ТББ	ААН	2017-2020
47	Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний экспортыг дэмжих маркетингийн цогц арга хэмжээг хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлэх	Маркетингийн цогц арга хэмжээ	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХөнҮБХЗГ, ХҮБХЗГ/	ТББ	ААН	2018-2020
48	"Мах, сүүний анхдугаар аяны үр шим" үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Үзэсгэлэн худалдаа	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	ТББ	ААН	2017-2020
49	Дэлхийн сүүний өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	Тэмдэглэлт өдөр	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	ТББ	ААН	2017-2020
50	"Мах, сүүний анхдугаар аянд нэгдэцгээе" хэвлэл мэдээллийн хэрэгслийн булан ажиллуулах	Хэвлэл мэдээлэл	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ХХААХҮЯ /ХҮБХЗГ/	ТББ	ААН	2017-2020

- ХХААХҮЯ - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам;
- БСШУСЯ – Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам;
- ҮСХ – Үндэсний статистикийн хороо;
- ҮХГ – Үндэсний хөгжлийн газар;
- МЭҮГ- Мал эмнэлэг, үржлийн газар;
- МХЕГ– Мэргэжлийн хяналтын ерөнхий газар;
- ТӨБХЗГ – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар.

- ШӨХТГ – Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар;
- ЖДҮХС – Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
- ХХААГ – Хүнс, хөдөө аж ахуйн газар;
- ХААИС – Хөдөө аж ахуйн их сургууль;
- ШУТИС – Шинжлэх ухаан, технологийн их сургууль;
- ЕБС – Ерөнхий боловсролын сургууль;
- ТББ – Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод;
- ААН – Аж ахуйн нэгж.

